



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/776

Арвайхээр


**Хөрөнгө зарцуулах тухай**

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, төсөл хөтөлбөр, үйлдвэрлэлийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн О.Гансүх нь ажиллаж байх хугацаандаа БНХАУ-тай хамтын ажиллагаа тогтоон махны үйлдвэрийг техник тоног төхөөрөмжөөр хангаж, үйл ажиллагааг нь хэвийн явуулах, орон нутагт үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж, гадаад хэлний өндөр боловсролтой боловсон хүчнийг дэмжиж, цаашид орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор 5000000 (таван сая) төгрөгийн орон байрны нэг удаагийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Дээрх нэг удаагийн буцалтгүй тусламжийг батлагдсан зардлаас тооцон олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101694